

**“Монгол бичгийн кодчилал – 2018”  
хурлын тайлан**

“Болорсофт” ХХК-аас зохион байгуулсан “Монгол бичгийн кодчилал-2018” хурал ШУТИС-ийн 1-р байрны Эрдмийн зөвлөлийн 203 тоот өрөөнд 2018 оны 11 сарын 20-ны өдрийн 10.20 минутад эхэллээ. Хурлыг Профессор Дэндэвийн Бадарч удирдав. Хуралд

- МУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл,
- МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар,
- Хэлний бодлогын үндэсний зөвлөл,
- Олон улсын Монгол судлалын холбоо,
- БСШУСЯ, Гадаад хэргийн яам,
- Харилцаа холбооны зохицуулах хороо,
- БНХАУ-ын типографийн мэргэжилтэн юникодын эксперт,
- Сэтгүүлчдийн нэгдсэн холбоо,
- ШУА-ын Инновац, мэдээллийн хэлтэс,
- ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн,
- БСШУСЯ-ы Боловсролын хүрээлэн,
- Шинжлэх ухаан технологийн их сургууль
- Монгол Улсын Их сургууль
- Монгол улсын Боловсролын их сургууль
- Өвөр Монголын Үндэсний их сургууль,
- Монголын цахилгаан холбоо ХХК,
- Болорсофт ХХК,
- Хүмүүн бичиг сонин,
- “Хөх тэнгэр” монгол бичиг хэрэглэгчдийн холбоо ТББ,
- Монгол бичиг фэйсбүүк хэрэглэгчдийн бүлгэм

гэсэн 21 байгууллага болон монгол бичгийн кодчилал ба хэрэглэгчдийн төлөөлөл болсон 42 хүн оролцлоо. Урилга явуулсан боловч Стандарт хэмжилзүйн газар болон Харилцаа холбоо мэдээлэл технологийн газраас төлөөлөл ирж хараахан амжсангүй. Хуралд академич Төмөртогоо, ардын багш С.Дулам нар хүрэлцэн ирсэн байлаа. Д-р Д. Бум-Очир орчуулагчаар ажиллав. Оролцогчдын жагсаалтыг хавсаргав.

**Хурлын нээлт**

Д. Бадарч хурлыг нээж үг хэлэв.

Юникодын техникийн хорооны тэргүүн Лиза Мүүрийн илгээсэн мэндчилгээг танилцуулав.

Мэндчилгээний хувийг хавсаргав.

ШУТИС-ийн дэд захирал Намнан хуралд амжилт хүсэж үг хэлэв.

С. Бадрал Юникодод анх монгол бичгийг оруулахад ажиллаж байсан Д-р. Намсрай,

Эрдэнэчимэг нарын мэндийг дамжуулж ирж чадаагүй шалтгааныг уламжлав.

**Хурлын илтгэлүүд**

Д. Лхагвасүрэн (МУИС-ийн Биологийн тэнхимийн дэд профессор, монгол бичгийн хэрэглэгчдийн төлөөлөл) “Монгол бичгийн кодчиллын асуудлууд”

Т. Жамъянсүрэн (үсгийн урлаг судлаач, каллиграфын мастер), С. Бадрал (программ хангамжийн инженер) “Монгол бичгийн кодчиллын асуудлуудыг шийдэх нь, Авиан зүйн тунгаамал загвар”

Т. Сэрчмаа (программ хангамжийн инженер) “Монгол бичгийн программ хангамжийн ирээдүй”

Лян Хай “Монгол бичгийн кодчиллын өнөөгийн байдал: шийдвэрлэвэл зохих асуудлууд?” зэрэг илтгэлүүдийг хэлэлцлээ.

Эдгээр илтгэлүүдийг мөн хавсаргав.

Б. Ундраа “MNS4932:2000 одоогийн стандарт”, Б. Энхдалай “Авиа зүйн сайжруулсан загвар” илтгэлүүдийн илтгэгчид нь ирсэнгүй. Хэдий тийм боловч, “Авиа зүйн сайжруулсан загвар” илтгэлийн эхийг оролцогчдод тарааж хэлэлцүүлээ.

### **Хурлын гарсан дүгнэлт, зөвлөмж**

Хурлын ажиллагаа нэлээд ажил хэрэгч болж, хэлэлцүүлж байгаа илтгэлийн талаар олон тооны асуулт гарч, мөн санал солилцоноос дараах дүгнэлтийг хийж байна.

1. Монгол бичгийн кодчиллын асуудалд манай эрдэмтэд ерээд оноос онцгой анхаарал тавьж, судалгааны ажил явуулсны үр дүнд 1999 онд анхны хувилбарыг доктор Эрдэнэчимэг, доктор Намсрай, ардын багш Чоймаа нарын хүмүүс хамтран боловсруулж, Өвөр монголын эрдэмтэдтэй хамтарсан зөвлөгөөн хийж, 2 тал өөрсдийн стандартыг батлуулах, уг кодчиллын системийг цаашид ЮНИКОД-д оруулж, байнга сайжруулан явахаар тохирсон байна. Энэхүү тохиролцооны хүрээнд манай улс 2000 онд монгол бичгийн үндэсний стандартыг баталж гаргасан байна. Харин Өвөр монголын тал энэ талаар ажлаа удаашруулж өөрийн стандартыг Өвөр монголын үндэсний хороогоор дөнгөж 2013 онд батлуулсан байна.
2. Тэр үед хэрэглэж байсан үйлдлийн системийн орчин өнөөдөр эрс шинэчлэгдэж олон тооны шинэ боломжтой болсон байна. Харин монгол бичгийн одоо мөрдөж байгаа кодчиллол нь цаг үеэсээ хоцорч, орчин үеийн технологийг хэрэглэхэд ихээхэн бэрхшээлтэй болсныг олон эрдэмтэд тэмдэглэлээ.
3. Өнгөрсөн хугацаанд Монгол бичгийн кодчиллын судалгааны ажил манай улсад зогсоогүй бөгөөд энэ чиглэлээр МУИС, ШУТИС хэд хэдэн эрдэмтэд бэлтгэж, улмаар тэдний үйл ажиллагааг Болорсофт компани дэмжиж, Монгол бичгийн кодчиллын талаарх анхны эрдэмтэд тухайлбал, доктор Эрдэнэчимэг, доктор Намсрай, ардын багш Чоймаа нарын зөвлөгөөний дор Монгол бичгийн гарал үүслээс эхлэн цаашид боловсронгуй болсон түүхэн хөгжил, түүний олон төрлийн талаар маш ул суурьтай суурь судалгааг явуулж, одоо байгаа кодчиллын дутагдалтай талуудыг шийдэх Авиа зүйн тунгаамал загварыг боловсруулсан байна. Түүнээс гадна ЮНИКОД-ын хурал зөвлөгөөнд идэвхтэй оролцож, тэдний тавьж байгаа шаардлага, технологийн шийдлийн талаар экспертийн түвшинд хүрсэн мэргэжилтэнтэй болжээ.
4. Харамсалтай нь Өвөр монголын эрдэмтдийн зүгээс ийм хэмжээний судалгааны ажил явуулаагүй зөвхөн монгол бичиг талаас нь голчлон анхаарч, кодчиллын талыг дутуу авч үзэж байгаа нь ЮНИКОД-оос тавьж байгаа шаардлагын дагуу биш учраас хоёр орны эрдэмтэн мэргэжилтнүүд санал бодлоо нэгтгэхэд саад болж байна. Энэ байдлыг хуралд оролцсон бие даасан гадаадын эксперт хурцаар шүүмжиллээ.

Хуралд оролцсон эрдэмтэн судлаачдаас дараах зөвлөмжийн дээр санал нэгдэж холбогдох байгууллагуудад уламжлагаар тогтлоо.

1. Монгол бичгийн юникодын боловсруулалт анхнаасаа авианы бичгийн онцлогийг тусгасан авианы загвараар эхэлсэн учраас авианы загвараа улам сайжруулан явах нь зүйтэй гэсэн байр суурь дээр санал нэгдэж байна. Ирээдүйд техник технологийн хөгжлөөс хамаарч зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд бусад тохиолдлыг авч үзэх нь зүйтэй юм.
2. Бие даасан эксперт Лян Хайн “Графетик загвар”, ХХМТГ-ын дэвшүүлж байгаа Өвөр Монголын одоогийн шийдэлтэй төстэй “сайжруулсан авиа зүйн загвар”, Болорсофтын “Тунгаамал авиан зүйн загвар” гэсэн гурван загварын давуу болон сул талыг харьцуулан авч хэлэлцээд сайжруулсан авиан зүйн загвар технологийн боловсронгуй шийдэл биш бөгөөд шүүмжлэлд өртөөд байгаа Өвөр монголын одоо барьж байгаа загвартай ижил төстэй болохыг монгол төдийгүй олон улсын эксперт тэмдэглэн хэлж байгаа учраас Болорсофтоос санал болгож байгаа “Тунгаамал авиан зүйн загвар” өнөөгийн нөхцөлд хамгийн зөв шийдэл гэж үзэж байна.
3. Төрийн байгууллагаас аливаа шийдвэрийг ганц нэг бие даасан экспертийн саналыг үндэслэх бус эрдэм шинжилгээний баталгаа нотолгоотой судалгаа шинжилгээний ажил дээр тулгуурлан гаргаж байх нь нотолгоонд тулгуурласан (evidence-based policy) төрийн бодлого боловсруулах өнөөгийн шаардлагад нийцэх болно. Иймд МУИС, ШУТИС, ШУА-ын эрдэмтдийн саналыг үндэслэн Болорсофт компанийн боловсруулсан бүтээл “Тунгаамал авиан зүйн загвар”-ыг монгол улсаас ЮНИКОД-д тавих санал болгож, үндэсний стандартаа шинэчилж, улмаар Өвөр монголын талтай хэлэлцэн тохиролцож, 2019 оны 4 сард манайд болох ЮНИКОД-ын хуралд нэгдсэн байр суурьтай оролцох нь зүйтэй гэж үзэж байна.

Хурлын удирдагч: Д. Бадарч



БОЛРСОФТ  
 БОЛРСОФТ  
 БОЛРСОФТ  
 БОЛРСОФТ

2018 оны 11 сарын 20

“Монгол бичгийн кодчилал - 2018” хуралд оролцогчдын бүртгэл

Байгууллага	Албан хаагч	Э-мэйл хаяг	Гарын үсэг
СТАНДАРТЧИЛАЛ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР	Б.Ундраа	undraa@masm.gov.mn	
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ	Т.Намнан	namnan@must.edu.mn	
	Н.Чулуунбанди	chuluunbandi@must.edu.mn	
	А.Эрдэнэбаатар	erka@must.edu.mn	
	Б.Батзолбоо	b.batzolboo@must.edu.mn	
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР	Б.Саруул	saruul@president.mn	
	С.Чулуунпүрэв	chuluunpurev@president.mn	
МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ	Д.Цэдэвсүрэн	tseder suren@msue.edu.mn	
ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ	С.Дулам	sosedula@gmail.com	
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ИННОВАЦ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС	Д.Батхуяг	d.batkhuyag@gmail.com	
	С.Цогзориг	tsogzol m 7179@yahoo.com	
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ	С.Мөнхбат	oranzul@mecs.gov.mn	
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ	Ч.Хатанбаатар	khatanbaatar@nsc.gov.mn	
	Энхзориг	enkhzorig@nsc.gov.mn	
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН	Ц.Батдорж	batdorj0007@gmail.com	
	Р.Отгонбаатар	ongond@gmail.com	
	Пүрэвсүрэн		
	Ууганбаатар		
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН	П.Лхагвасүрэн	P.Lkhagva@yahoo.com @mier.mn	
ХАРИЛЦАА ХОЛБОО МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ГАЗАР	Б.Билэгдэмбэрэл		
	Б.Бадамсүрэн		
	Д.Энхдалай		
МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ	Ш.Чоймаа	8899-3886	
	Ч.Лодойравсал	lodoiravsal@num.edu.mn	
	Ч.Алтангэрэл	altangerel@num.edu.mn	
	Э.Мөнх-Учрал	enkhuchral@gmail.com	
БНХАУ - Типографын мэргэжилтэн	Лианг Хай	lianghai@gmail.com	

Байгууллага	Албан хаагч	Э-мэйл хаяг	Гарын үсэг
Хүмүүн бичиг сонин	Б.Элбэгзаяа		
	Б.Хандмаа	khandsain@yahoo.com	
Хөх тэнгэр Монгол бичиг хэрэглэгчдийн холбоо ТББ	Г.Цогт-Эрдэнэ	g.tsogterdene@gmail.com	
	Н.Гантуяа	gantuyana@yahoo.com	
	Ж.Зоригт	TeraReader@gmail.com	
	Д.Цэнд-Аюуш	andshuler@gmail.com	
	Г.Бямбаа	nikedong21@gmail.com	
О.Ананд			
Олон улсын Монгол судлалын холбоо	Д.Төмөртоогоо		
Сэтгүүлчдийн нэгдсэн холбоо	М.Молотов	molotovtuvden@yahoo.com	
Монголын цахилгаан холбоо ХК	А.Тэгшжаргал	tegshee@mtcone.net	
ШУ академ	Э.Молотов	moba@0103.yahoo.com	
Монгол улсын Гадаад хэргийн яам	Х.Мандахцэцэг В.Учрал	dep11@mfa.gov.mn	
МОНГОЛ БИЧИГ ХЭРЭГЛЭГЧДИЙН ТӨЛӨӨЛӨЛ	Д.Лхагвасүрэн	lhaqvasuren@gmail.com	
	Ч.Ванчигдаш	vanchigaa@gmail.com	
НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦЫН ГАЗАР	Б.Бат-Эрдэнэ	baterdene.b@ulaanbaatar.mn	
БОЛОРСОФТ ХХК	С.Бадрал	badral@bolorsoft.com	
	Т.Сэрчмаа	serchmaa@bolorsoft.com	
	Ч.Мөнхнаран	munkhnaran@bolorsoft.com	
	Т.Жамъянсүрэн	onolmn@yahoo.com	
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО	Т.Батболд	batbold@crc.gov.mn	
ИУИС	Д.Тул Очир Бат хууч	dbochir@yahoo.com	
МУИС	Т.Цэрэн	tsereengoo@gmail.com	
Мөнхчин бичигчдийн холбоо	1. Г.Учрал 2. Батсүрэн	amun 756 damchov-barsuren@yahoo.com	
Өвөр монгол Ундорчийн их сургууль	АН Тобб П.Улаан хүү	66811344@99.com Pulaankhuk@gmail.com	
Нийт			

Хуралд оролцогч нийт 42 хүний гарын үсэгтэйгээр хурлын дарга Д.Бадарчид хүлээлгэн өгөв. Оролцогчдын бүртгэлийг хийж, хүлээлгэн өгсөн:

Ч.Мөнхнаран /...../

Бүртгэлийг хүлээн авч, дүгнэлтэд нэгтгэсэн:

Д.Бадарч /...../

2018 оны 11 сарын 20